



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2014 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

**Хуулийн хэрэгжилтийг хангах асуудлаар
чиглэл өгөх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.4 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Өргөдлийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

Нэг.Эрүүл мэндийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, Монгол хүний эрүүл мэндийг хамгаалах тогтолцоог шинэчлэн сайжруулах, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх талаар дараах арга хэмжээг судлан хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н.Алтанхуяг/-т чиглэл болгосугай:

А.Хүн амын өвчлөлийн шалтгааныг судлан тогтоож, түүнийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх хүрээнд:

1/Хүн амын өвчлөлийн шалтгааныг судлан тогтоох, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх тогтолцоог боловсронгуй болгох, аймаг, нийслэлд байгуулах нийгмийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг эрүүл мэндийн газрын үйл ажиллагаатай уялдуулан үр ашигтай зохион байгуулах;

2/Урьдчилан сэргийлэх үзлэгийг чанаржуулах, үр дүнг сайжруулах чиглэлээр бодлого зохицуулалтын арга хэмжээ авах.

Б.Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, аюулгүй байдлыг хангах талаар:

1/Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношилгоо эмчилгээний төвийн бүтэц, үйл ажиллагааны стандартыг хангаж ажиллуулах, шаардагдах санхүүжилтийг шийдвэрлүүлэх;

2/Нийгмийн эрүүл мэндийн төв, түргэн тусламжийн төв, клиникийн үйл ажиллагааны дүрэм, журам, стандартыг боловсруулан баталж мөрдүүлэх, шинэчлэх;

3/Эмчилгээний стандарт, удирдамжуудыг баталж, мөрдүүлэх ажлыг эрчимжүүлэх;

4/Дүүргийн нэгдсэн эмнэлгүүдийг бүтэц, үйл ажиллагааны стандартын дагуу ажиллуулах, дотор, хүүхэд, эх барих, эмэгтэйчүүд, ерөнхий мэс засал, шүд, мэдрэл, халдварт зэрэг 7-оос доошгүй чиглэлээр эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг болгож, иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээг ойртуулах;

5/Өрхийн эрүүл мэндийн төвийн төсвөөс санхүүжин нөхөрлөл хэлбэрээр ажиллаж буй нэгжүүдийн үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн орчинг тодорхой болгох;

6/Халдвар тархахаас сэргийлэх үүднээс халдварт өвчний буюу сүрьеэгийн эмнэлгийг хүн амын суурьшлын бүсээс гаргах;

7/Эмнэлгийн үйлчилгээг хөнгөн шуурхай болгох, цахимжуулах, үйлчилгээг олон улсын жишигт хүргэх, мэдээллийн сан байгуулах, эмчилгээний чанар, аюулгүй байдалтай холбоотой мэдээллийг ил тод, иргэдэд хүртээмжтэй болгох;

8/Эмнэлгийн үйлчилгээний чанар, анхан шатны эмнэлгийн тусламж, үйлчилгээг сайжруулах, сум, өрхийн эмнэлэгт ерөнхий мэргэжлийн, ажлын туршлагатай эмч нар ажиллуулах.

В.Эрүүл мэндийн салбарын бодлого зохицуулалт, үнэ тариф, өмчийн хэлбэр, боловсон хүчний талаар:

1/Улсын хэмжээнд ажиллах бүх шатны эмнэлгийн тогтолцоо, байршлын зураглалыг бодит шаардлагад үндэслэн судалж гаргах, түүнд шаардагдах төсөв, хөрөнгө, хүний нөөц, тоног төхөөрөмжийн судалгааг гаргах;

2/Барьж эхлүүлсэн эмнэлгийн барилгуудыг шуурхай ашиглалтад оруулах, үйлцэтгэлийн хувь хэмжээг харгалзан санхүүжилтийг нэн тэргүүнд шийдвэрлүүлэх;

3/Шинээр байгуулах эмнэлгүүдийг хүн амын суурьшлыг харгалзан төлөвлөх, эмнэлгүүдийн тусламж үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх, үнэ тарифын бодлого, эрүүл мэндийн даатгалын системийг боловсронгуй болгож уялдуулах;

4/Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийг нэн тэргүүнд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, төсвийн тооцоо, судалгааг гаргаж шийдвэрлүүлэх;

5/Эмч, эмнэлгийн ажилтнуудыг бэлтгэх, мэргэшүүлэх тогтолцоог боловсронгуй болгох, сургалтын бааз, сургуулийн судалгаа шинжилгээний хүрээлэнгүүд байгуулж, хөгжүүлэхийг дэмжих;

6/Эмч, эмнэлгийн ажилтны цалин, хангамжийг нэмэгдүүлэх, нийгмийн баталгааг хангах;

7/Эмч, эмнэлгийн ажилтнуудыг ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хувийн эмнэлгүүдэд давхар ажиллахыг зогсоох, ажлын цагийн хуваарийг Монгол Улсын Хөдөлмөрийн хуульд нийцүүлэх арга хэмжээ авах;

8/Улсын эмнэлгүүдийн удирдлага, зохион байгуулалт, өмчлөлийн хэлбэрийг оновчтой болгох, хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх;

9/Мэргэжлийн салбар зөвлөлүүдийн ажиллах нөхцөл, эрх зүйн орчинг сайжруулан, шаардлагын түвшинд хүргэж ажиллуулах;

10/Тусгай зөвшөөрөл олгоход тавигдах шаардлагыг тодорхой болгох замаар хүнд суртал, чирэгдлийг арилгах;

11/Дотоодын нийт бүтээгдэхүүний 4-5 хувийг эрүүл мэндийн салбарт зарцуулах талаарх Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын холбогдох зөвлөмжийг үе шаттайгаар хэрэгжүүлэх;

12/Эмнэлгийн тусламж үйлчилгээний талаарх салбарын яамны шийдвэр, эрх зүйн актуудад хяналт, үнэлгээ хийж, өөрчлөх, шинэчлэн баталж мөрдүүлэх;

13/Шаардлагатай бол эмнэлгийн тухай болон эмч, эмнэлгийн ажилтны хариуцлагын тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

Хоёр.Тогтоолын хэрэгжилтийг хангах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажиллаж, биелэлтийг 2014-2015 оны намрын чуулганы хугацаанд багтаан тус Байнгын хороонд танилцуулахыг Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасгай.

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.БУРМАА